



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2019 ОНЫ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

АУДИТЫН КОД: /НАГ-2020/05/-НА

БУЛГАН ХОТ 2020 ОН

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын
Дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn
Аудитын менежер Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Намчинсүрэн
Утас: 70342716 Цахим хаяг: namchinsureng@audit.gov.mn
Аудитор З.Ганбаатар
Утас: 703427116 Цахим хаяг: ganbaatarz@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас www.audit.mn

2019 он

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН: Булган аймаг дахь Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор

Д.Анхбаяр

Аудитын менежер

Ж.Энхцоодол

Ахлах аудитор

Г.Намчинсүрэн

Аудитор

З.Ганбаатар

2019 оны 11 дүгээр сар

Ой аймаг дахь Төрийн аудитын газар
адрес: Улаанбаатар

Адрес: Улаанбаатар
дугаар: 70342495, 70342716
телефон: 70342580
факс: 70342580

ОАЯГ:

Аймаг, нутгийн удирдлагын
ордон

адрес: 401 дугаар

Bulgan@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар.....3

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга, зүй, шалгуур үзүүлэлт.....4-5

Бүлэг 1 Аймаг, сум ОНХС-гийн эх үүсвэрийг хууль дүрэм журамд заасны дагуу эх үүсвэр тус бүрээр төлөвлөж, бүрдүүлэх нөхцөл боломж бүрдээгүй, АОНХС-гаас сумдад шилжүүлэх шилжүүлгийг аргачлалын дагуу хуваарилсан байна6-11

Бүлэг 2 Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хууль тогтоомж, зааврыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.....11-18

Бүлэг 3 ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд холбогдох хяналт шалгалтыг хийжээ.....18-21

Дүгнэлт.....22

Зөвлөмж.....22-23

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
СЯ	Сангийн яам
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл
АМХБАТЗ	
АОНХС	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХШДАХ	Хяналт шинжилгээ, дотоод аудитын хэлтэс

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Монгол Улсын ИХ Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2019 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Үндэсний аудитын газрын 2020 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, аудитын тайланг УИХ-д танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудит хийлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх ;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр, арга хэмжээг журмын дагуу төлөвлөж, зарцуулсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг, хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх.

Аудитын хамрах хүрээ:

Аудитад ОНХНС, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг 2019 оны орлого бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга, хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналыг СЯ болон аймаг, нийслэл, сум дүүргийн ИТХ, ЗДТГ, СТСХ, ЭЗТХ, Баг хороодын Засаг дарга, ИНХ-ыг хамруулан шалгана.

Эрсдэлийн үнэлгээ:

Төлөвлөлтийн үе шатны ажлын явцад цуглуулж судалсан баримт, материал, хамрах хүрээ, нөхцөл байдалд хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн дээрх сангийн хөрөнгийн зарцуулалтад хийх аудитын эрсдэлийн ерөнхий үнэлгээг “Дунд” гэж үнэллээ.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 3000, АДБОУС 4000 дугаар стандартууд, Төрийн хяналт шалгалтын стандарт,

арт, МУЕА-ын 2016 оны А/ 146 тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан, Сангийн яам, аймаг нийслэл, сум, дүүргийн Засаг даргын

Тамгын газрын Санхүү, төрийн сангийн болон холбогдох хэлтсийн албан тушаалтантай ярилцах, иргэдээс санал асуулга авах, судалгаа авч дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах арга зүйг ашиглан аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглана. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 17 -ны өдрийн 230 дугаар тогтоолоор баталсан орон нутгийн хөгжлийн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал;
- Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19 -ны өдрийн 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”;
- Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”;
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам;

Ерөнхий мэдээлэл:

Аймгийн ОНХС: Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-ын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолоор нийт 1775.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээг баталж, 2019 оны 09 дүгээр сарын 27 -ны өдрийн XIII/01 дүгээр тогтоолын өөрчлөлтөөр 14 төсөл арга хэмжээнд 1842.0 сая төгрөг баталсан ч 1 төсөл, арга хэмжээнд иргэдийн саналыг аваагүй батлан хэрэгжүүлж ажилласан байна.

Сумдын ОНХС: Булган аймгийн ОНХС-гаас 16 суманд 2019 онд 1369.1 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж 1362.1 сая төгрөг санхүүжилтийг олгож нийт сумдад 7.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосноос Дашинчилэн суманд 6.1 сая төгрөг дутуу олгосон нь сумдын нийт дутуу олгосон санхүүжилтийн 87.1 хувийг эзэлж байна.

Тайлант онд нийт аймгийн хэмжээнд 178 төсөл, арга хэмжээнд 3803.2 сая төгрөгийг баталсанаас дутуу санхүүжилт олгосон 1 төсөл, арга хэмжээ 187.4, дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээ 3, Огт хэрэгжээгүй төсөл, арга хэмжээ 23 байна.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан уу?

Бүлэг I

Аймаг, сум ОНХС-гийн эх үүсвэрийг хууль дүрэм журамд заасны дагуу эх үүсвэр тус бүрээр төлөвлөж, бүрдүүлэх нөөц боломж, нөхцөл бүрдээгүй харин АОНХС-гаас сумдад шилжүүлэх шилжүүлгийг аргачлалын дагуу хуваарилсан байна.

1.2.1 Аймаг, сум ОНХС-гийн эх үүсвэрийг төлөвлөхдөө холбогдох журамд заасан эх үүсвэр бүрээр бүрэн тооцож төлөвлөх нөөц боломж, нөхцөл бүрдээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2¹ болон Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 2.2²-т аймаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн бүрдлийг заажээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн төлөвлөлтийг сумдын дүнгээр хүснэгтээр харуулбал:

/мян.төг/

№	Сумдын нэрс	Итгэлцүүрээр хуваарилагдах хөрөнгө	Тогтвортой амьжиргаа төслийн дэмжлэг	Тогтвортой амьжиргаа төслийн урамшуулал	АМХБАТЗ-ийн төлбөрийн 50 хувь
1	Баян-агт	44,924.80	21,463.40	13,889.00	
2	Баяннуур	24,287.80	11,603.80		13,825.60
3	Бугат	27,902.20	13,330.70		47,082.00
4	Булган	58,906.40	28,143.20	18,508.00	
5	Бүрэгхангай	36,739.80	17,552.90		68,765.10
6	Гурванбулаг	42,099.50	20,113.50	13,240.30	1,868.80
7	Дашинчилэн	39,791.40	19,010.80	12,047.30	16,320.90
8	Могод	36,382.80	17,382.30		
9	Орхон	38,058.40	18,182.90		
10	Рашаант	43,330.70	20,701.70	13,656.40	4,166.70
11	Сайхан	41,804.30	19,972.50	13,187.80	6,446.20
12	Сэлэнгэ	52,113.70	24,898.00		38,949.40
13	Тэшиг	80,465.80	38,443.60		9,415.10

¹ Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

² Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан, орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэр

14	Хангал	47,143.40	22,527.30		
15	Хишиг-Өндөр	32,806.60	15,673.80		15,844.50
16	Хутаг-Өндөр	71,809.90	34,308.10		
	Нийт дүн	718,567.50	343,308.50	84,528.80	222,684.30

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг төлөвлөхдөө аймаг, сумд ОНХНС-гаас хуваарилах эх үүсвэрийг итгэлцүүрт үндэслэн аймгийн ОНХС-д 1676.6 сумдын ОНХС-д 718.6, тогтвортой амьжиргаа -3 төслийн дэмжлэг 343.3, төслийн урамшуулал авах нөхцөл хангасан нэр бүхий 6 суманд 84.5, АМХБАТЗ-ийн төлбөрийн 50 хувь 222.6 сая төгрөгийг хуваарилахаар төлөвлөж, тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор дотоод, гадаадын хандив, тусламж, зарлагын хэмнэлтийг урьдчилан тооцох боломжгүй, татварын хэмжээнд өөрчлөлт ороогүй зэрэг нөхцөл байдлаас ОНХС-ийн эх үүсвэрийг хууль, журамд заасан эх үүсвэр бүрээр төлөвлөх нөхцөл бүрдээгүй байна.

1.2.2. ОНХС-гийн эх үүсвэрийг хуульд заасан эх үүсвэр тус бүрээр бүрдүүлэх нөөц боломж, нөхцөл бүрдээгүй байна.

Аймаг, сум нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2³ болон Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон Орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлгийг тооцох аргачлал”-ын 2.2-т заасны дагуу аймаг, сумд бүрэн бүрдүүлээгүй байна.

Дор дурдсан сумд ОНХС-гийн эх үүсвэрийг хууль, журамд заасан зарим нэр төрөл болон бусад эх үүсвэрээр нэмэгдүүлсэн байна.Тухайлбал:

- Баян-Агт сум тендерийн бичиг баримтын үнэ 250.5,
- Бүрэгхангай сум уул уурхайн аж ахуй нэгжүүдийн нийгмийн хариуцлагын гэрээний дагуу хандив 211189.2, өвс тэжээлийн үнэ 145.0,
- Булган сум өвс тэжээлийн үнэ 11094.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлжээ.

Аймаг болон дээр дурдсан сумдаас бусад сумд зөвхөн ОНХНС-гийн орлогын шилжүүлгээр бүрдүүлсэн нь нь тухайн орон нутгийн онцлогоос хамаарч дотоод гадаадын хандив, тусламж аваагүй, татварын хэмжээнд өөрчлөлт ороогүй зэрэг шалтгаантай холбоотой байна.

2019 оны Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийн бүрдүүлэлт:
/сая.төг/

Эх үүсвэр	Дүн	Хувийн жин
Өмнөх оны үлдэгдэл	544.6	12.7
ОНХС болон улсын төсвөөс олгосон шилжүүлэг	3087.6	72.0
Тогтвортой амьжиргаа -3 төсөл	427.8	10.0
Дотоод гадаадын хандив, тусламж	211.3	5.0
Бусад орлого	11.5	0.26
Нийт дүн	4282.9	100

³ Орон нутгийн хөгжлийн сан нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

Тогтвортой амьжиргаа-3 төслийн урамшуулал авах нөхцөл хангасан Баян-Агт, Булган, Гурванбулаг, Дашинчилэн, Рашаант, Сайхан зэрэг сумд 12047.3-18508.0 мянган төгрөгийн урамшуулал авч эх үүсвэрийг нэмэгдүүлж бусад сум урамшууллаар ОНХС-гийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.

Иймд ОНХС-гийн эх үүсвэрийг орлогын эх үүсвэр тус бүрээр төлөвлөх, бүрдүүлэхэд аймаг, сумын төсвийн ерөнхийлөн захирагч нар идэвх санаачилгатай ажиллах шаардлагатай байна.

1.2.3. Аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн сангаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу холбогдох хууль журмыг баримталж хуваарилсан ч баталсан хуваарийн дагуу санхүүжилтийг шилжүүлээгүй байна.

ОНХНС, улсын төсвөөс аймагт олгох 3570.2 сая төгрөгөөс орон нутгийн суурь зарлага болох мал эмнэлгийн үйлчилгээний зардал 429.9, тохижилт үйлчилгээний зардалд 94.4 сая төгрөгийг шууд хуваарилан, үлдэх 1676.7 сая төгрөгийг аймгийн ОНХС-д, 1369.1 сая төгрөгийг сумдын орон нутгийн хөгжлийн санд хуваарилжээ.

Аймгийн ОНХС-гаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2⁴, 59.3⁵, Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан “ОНХНС болон ОНХС-гаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ын 8.2⁶, 8.3⁷-т заасны дагуу хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах үзүүлэлтийн хувийн жин зэрэг шалгуур үзүүлэлтийг үндэслэн дараах байдлаар хуваарилсан байна.

⁴ Аймаг, нийслэл нь Орон нутгийн хөгжлийн сангаас болон улсын төсвөөс олгосон шилжүүлгийг доор дурдсанаар сум дүүргийн Орон нутгийн хөгжлийн санд хуваарилна:

⁵ 59.3.Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тухайн жил орон нутгийн төсөвт олгох шилжүүлгийг тодорхойлохдоо дараах итгэлцүүрийг үндэслэн тогтооно:

⁶ Аймаг, нийслэл нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлогын шилжүүлгийн дүнгээс энэхүү аргачлалын 8.1-д зааснаас бусад хэсгийг Төсвийн тухай хуулийн 59.2.2-т зааснаас доошгүй хувь хэмжээгээр сум, дүүргийн ОНХС-нд хуваарилагдах дүнг тооцох бөгөөд энэ аргачлалын 8.1.1 болон 8.1.2-т заасны дагуу хөрөнгө хуваарилагдсан сум, дүүргийг мөн багтаан тооцно.

⁷ Аймаг. Нийслэл нь энэ аргачлалын 8.2-т заасны дагуу хуваарилалтыг хийхдээ хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах үзүүлэлтийн хувийн жинг дараах байдлаар тооцно.

8.3.1. Хүн амын тооноос хамаарах -40 хувь

8.3.2. алслалтаас хамаарах-30 хувь

8.3.3. нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамаарах-30 хувь

АОНХС-аас сумдын ОНХС хуваарилсан хөрөнгө

/мян.төг/

№	Сумдын нэрс	1. Хүн амын тооноос хамаарах		2. Алслалтаас хамаарах				3. Нутаг дэвсгэрээс хамаарах		Итгэлцүүрт үндэслэсэн хуваарилалтын дүн
		Хүн амын тоо /2017 оны	Хүн амын тооноос хамааруулсан олгох дүн	Аймаг хүртэлх зай	Алслалтын индекс	Хүн амын тоонд жинлэсэн алслалтын	Алслалтаас хамаарсан	Газар нутаг	газар нутгаас хамаарсан	
1	Баян-Агт	3218	14912.1	150	0.61	1962.2	16336.1	3079	13676.6	44924.8
2	Баяннуур	1861	8623.8	181	0.74	1369.3	11399.7	960	4264.2	24287.8
3	Бугат	2277	10551.6	52	0.21	481.3	4007.2	3004	13343.5	27902.2
4	Булган	12616	58462.2	0	0.00	0.0	0.0	100	444.2	58906.4
5	Бүрэгхангай	2888	13382.9	80	0.33	939.2	7819.1	3498	15537.8	36739.8
6	Гурванбулаг	3219	14916.8	140	0.57	1832.0	15251.7	2686	11931.0	42099.5
7	Дашинчилэн	3037	14073.4	150	0.61	1851.8	15417.2	2319	10300.8	39791.4
8	Могод	2729	12646.1	131	0.53	1453.2	12098.9	2620	11637.8	36382.8
9	Орхон	3595	16659.1	22	0.09	321.5	2676.7	4215	18722.6	38058.4
10	Рашаант	3215	14898.2	220	0.89	2875.2	23937.2	1012	4495.2	43330.7
11	Сайхан	3662	16969.6	101	0.41	1503.5	12517.3	2773	12317.4	41804.3
12	Сэлэнгэ	3332	15440.4	135	0.55	1828.5	15223.3	4829	21450.0	52113.7
13	Тэшиг	3563	16510.9	246	1.00	3563.0	29663.4	7720	34291.5	80465.8
14	Хангал	4704	21798.2	113	0.46	2160.8	17989.4	1656	7355.8	47143.4
15	Хишиг-Өндөр	3158	14634.1	68	0.28	872.9	7267.6	2455	10904.9	32806.6
16	Хутаг-Өндөр	4952	22947.4	143	0.58	2878.6	23965.5	5605	24896.9	71809.9
НИЙТ ДҮН		62026	287427.0	1932	7.85	25893.1	215570.2	48531	215570.2	718567.4

Аймгийн ОНХС-гаас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг холбогдох, хууль, журам, заавар, аргачлалын дагуу хуваарилж баталсан ч аймгийн ОНХС, мал эмнэлэг, зарим сумдын санхүүжилтийг нийт 54658.1 мянган төгрөгөөр дутуу олгосон байна.

АОНХС-аас сумын аймаг, сумын ОНХС-д олгосон шилжүүлэг

/мян.төг/

№	Сумын нэр	Жилийн батлагдсан төсөв	Санхүүжилтийн эрх /өссөн дүнгээр/	Санхүүжилтийн зөрүү дүн
1	Баян-Агт	80,277,200.00	80,152,400.00	124,800.00
2	Баяннуур	49,717,200.00	49,691,600.00	25,600.00
3	Бугат	88,314,900.00	88,314,900.00	-

4	Булган	105,557,600.00	105,557,600.00	-
5	Бүрэгхангай	123,057,800.00	122,792,700.00	265,100.00
6	Гурванбулаг	77,322,100.00	77,253,300.00	68,800.00
7	Дашинчилэн	87,170,400.00	81,049,500.00	6,120,900.00
8	Могод	53,765,100.00	53,765,100.00	-
9	Орхон	56,241,300.00	56,241,300.00	-
10	Рашаант	81,855,500.00	81,855,500.00	-
11	Сайхан	81,410,800.00	81,264,600.00	146,200.00
12	Сэлэнгэ	115,961,100.00	115,868,900.00	92,200.00
13	Төшиг	128,324,500.00	128,209,400.00	115,100.00
14	Хангал	34,835,400.00	34,835,400.00	-
16	Хишиг-Өндөр	64,324,900.00	64,324,900.00	-
17	Хутаг-Өндөр	106,118,000.00	106,118,000.00	-
15	Хялганат	34,835,300.00	34,835,300.00	-
	НИЙТ ДҮН	1,369,089,100.00	1,362,130,400.00	6,958,700.00
1	Аймаг	1,676,657,300.00	1,632,166,668.25	44,490,631.75
2	Хот тохижилт	94,454,700.00	94,454,700.00	-
3	Мал эмнэлэг	429,870,000.00	426,661,367.00	3,208,633.00
	НИЙТ ДҮН	3,570,071,100.00	3,515,413,135.25	54,657,964.75

Дээрх дутуу олгосон санхүүжилтийн шалтгааныг тодруулахад: Сангийн яам нь аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст 2-4, 7-9 дүгээр саруудад нийт 314149.5 мянган төгрөгийг дутуу, 5,6,10-12, саруудад 259491.4 мянган төгрөгийг илүү жилийн нийт дүнгээр 54658.1 мянган төгрөгийг дутуу шилжүүлсэнтэй холбоотой байна.

Сангийн яамнаас баталсан санхүүжилт дутуу ирсэнтэй холбоотойгоор аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс нь дээрх сумдад 6958.5 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу мөн АОНХС-гаас сумдын ОНХС-д 9, 10, 11 дүгээр саруудад санхүүжилтийг олгох орлогын шилжүүлгийг батлагдсан хуваарийн дагуу олгоогүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.4⁸, 41.2.5⁹ дахь заалтуудыг тус тус зөрчхөд хүргэсэн байна.

⁸ төсвийн сар, улирлын хуваарийг баримталж ажиллах;

⁹ энэ хуулийн 37.1.8-д заасан эрхийн хүрээнд төсвийн байгууллагын зардлыг санхүүжүүлэх;

Иймд сангийн яам нь аймгийн ОНХС-д шилжүүлэхдээ Төсвийн тухай хууль болон дээрх батлагдсан дүн, хуваарийн дагуу шилжүүлэх шаардлагатай байна.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль журамд заасны дагуу үр дүнтэй төлөвлөж, зарцуулсан уу ?

Бүлэг II Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хууль тогтоомж, зааврыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

2.1.1. Сумын түвшинд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох журам зааврыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Сумын Засаг дарга нь ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.5¹⁰, 6.5.6¹¹, 63 дугаар зүйлийн 63.1¹², 63.2¹³, 63.3¹⁴, 63.4¹⁵, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу тус тус төлөвлөхөөр заажээ.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, иргэд, олон нийтийн оролцоог хангахдаа саналын хуудсаар нээлттэй санал асуулга авах, иргэдийн саналыг эрэмбэлж тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлэх ажлыг хийж хэвшсэн боловч хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль, журмын шалгуур үзүүлэлтийг баримтлаагүй дараах зөрчлүүд гарсаар байна.

¹⁰ 6.5.5. Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх

¹¹ 6.5.6. Төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай

¹² 63 дугаар зүйл. Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах;

¹³ Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

¹⁴ Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ

¹⁵ Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 63.3-т заасан саналыг хэлэлцэж, төсвийн төсөлд тусган, батална

Суманд хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг төлөвлөхтэй холбоотой зөрчлийн дүн /сая.төг/

Д/д	Сум	Иргэдийн санал аваагүй төсөл арга хэмжээ		ТЭЗҮ, зураг, төсөвгүй		ОНХС-ийн зорилгод нийцээгүй		Нийт дүн	
		тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг	тоо	Төсөвт өртөг
1	Баяннуур					1	15.7	1	15.7
2	Бугат	3	77.8	4	19.8			7	97.6
3	Дашинчилэн					1	5.1	1	5.1
4	Хутаг-Өндөр	11	103.2	3	32			14	135.2
5	Тэшиг	4	81.2	4	38.3			8	119.5
6	Баян-агт	8	45.2					8	45.2
7	Сайхан	5	27.1	3	23	3	13.2	11	63.3
8	Булган	1	12.4	4	27.8			5	40.2
9	Орхон					1	10.0	0	10
	Нийт дүн	32	356.9	18	113.1	6	44.0	55	504

Нийт зөрчлийн 58.1 хувь нь иргэдээс санал аваагүй, 32.7 хувь нь урьдчилсан тооцоолол, батлагдсан зураг, төсөвгүй, 10.9 хувь нь ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний чиг үүрэг, зорилгод нийцээгүй төсөл арга хэмжээ байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹⁶, Төсвийн тухай хуулийн 60.3.6¹⁷, ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 3.1.3¹⁸–д заасан заалтыг тус тус зөрчжээ.

Бугат сум 4000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн үлдэгдлийг дараа жилийн төсөвт тусгаж батлуулаагүй нь “ОНХС-гийн заавар”-ын 6.8 “ОНХС-гийн хөрөнгийн хэрэгжүүлэхээр тухайн онд төлөвлөж ажлын гүйцэтгэл баталгаажсан боловч санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг дараа жилийн төсөвт тусгаж батлуулна.” гэсэн заалтыг зөрчжээ.

Сумдын түвшинд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө зураг, төсөвгүй ажлыг төлөвлөж байгаа нь зураг төсвийг урьдчилж хийлгэхэд тухайн төсөл, арга хэмжээ ИТХ-аар батлагдахгүй байх, мөн зураг төсөв хийлгэх өртөг өндрөөс тухайн суманд хуваарилагдсан хөрөнгийн ихэнх хувь нь зарцуулагдах, эх үүсвэр хүрэлцдэггүй гэсэн шалтгаантай холбоотой байна. Эдгээр

¹⁶ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

¹⁷ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ.

¹⁸ ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийгдсэн, бусад холбогдох зөвшөөрөлтэй байх

шалтгаанаас үүдэн ихэвчлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг ИТХ-аар батлуулсны дараа ТЭЗҮ, зураг, төсвийг төсөвт өртөгт багтаан хийдэг нийтлэг зөрчил байна.

Мөн аймаг, сумдын ИТХ-аар төсвийн тодотгол хийхдээ иргэдээс санал авч эрэмбэлэгдээгүй, зураг, төсөв, ТЭЗҮ-гүй төсөл арга, хэмжээг нэмж баталсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Төсвийн тухай хуулийн 60.3.6, ОНХС-гийн 3.1.3 хуулийн заалттай бүрэн нийцээгүй байна. Тухайлбал:

- Аймгийн ИТХ 10000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээ /Булган сумын төвийн хяналтын камерын засварын ажил/
- Булган сумын ИТХ 5000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээ /12 жилийн 1 дүгээр сургуульд Монгол хэл, бага ангийн кабинет байгуулах/
- Хангал сумын ИТХ 20000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээ /Хялганат тосгоны 1.5 км хатуу хучилттай авто замын зураг төсөв, Тосгоны хэмжээнд эрчим хүчний хуучин шугам сүлжээг муудсан, доголдолтой газруудад шинэчлэл хийх, айл өрх албан байгууллагуудын хаягийг шинээр хийлгэх/

Дээрх илэрсэн зөрчилд зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, таслан зогсоох, холбогдох дүрэм журмыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах зөвлөмж хүргүүлэн ажиллаа.

2.1.2. Аймаг, сумын түвшинд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох хууль тогтоомж, зааврыг бүрэн хэрэгжүүлэн ажиллажээ.

Аймгийн Засаг дарга нь ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.5¹⁹, 6.5.6²⁰, 63 дугаар зүйлийн 63.1²¹, 63.2²², 63.3²³, 63.4²⁴ дэх хэсэг, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дагуу тус тус төлөвлөхөөр заажээ.

¹⁹ 6.5.5. Хөтөлбөр, төсөл, арга хэмжээний ач холбогдлын эрэмбэ, хэрэгжүүлэх дараалал, арга замыг тодорхойлох шийдвэрт олон нийтийн саналыг харгалзан үзэх

²⁰ 6.5.6. Төсвийн асуудлаар иргэд, төрийн бус байгууллагаас гаргасан санал, дүгнэлтийг эрх бүхий этгээд нь шийдвэртээ хэрхэн тусгасан тухай

²¹ 63 дугаар зүйл. Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн оролцоог хангах;

²² Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна.

²³ Энэ хуулийн 63.2-т заасны дагуу баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаас ирүүлсэн саналыг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар ач холбогдол, тухайн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусган сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ

²⁴ Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 63.3-т заасан саналыг хэлэлцэж, төсвийн төсөлд тусган, батална

Аймгийн Засаг даргын 2018 оны 09 дүгээр сарын 20-ны А/550 тоот захирамжаар ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтын төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулж нийт 78 төсөл хөтөлбөр, арга хэмжээнээс холбогдох журмын дагуу 12 арга хэмжээг ИТХ-аар батлуулахаар санал оруулж батлуулж холбогдох хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэн ажилласан байна.

2.2. Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль тогтоомжийг бүрэн баримталж ажиллаагүй байна.

2.2.1. Зарим үнэлгээний хороо, ажлын хэсэг холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна.

ОНХС-гийн хөрөнгөөр 2019 онд өмнөх онд дутуу хэрэгжсэн 9, шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 169 буюу нийт 178 төсөл, арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу зохион байгуулсан бөгөөд 5 хувь буюу 8 ажлыг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар, 18 хувь буюу 30 ажлыг тендер шалгаруулалтын онцгой журмаар, 63 хувь буюу 106 ажлыг шууд гэрээ байгуулах журмаар, 15 хувь буюу 24 ажлыг шууд худалдан авалтаар гүйцэтгэсэн байна.

ОНХС-гийн хөрөнгөөр худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны тоон мэдээлэл

/сая.төг/

№	Үзүүлэлт	Худалдан авах ажиллагааны журам									
		Нээлттэй тендер шалгаруулалт		Хязгаарлагдмал		Харьцуулалтын арга		Шууд		Бусад	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймаг ОНХС	6	1388.1			2	48.5	3	250.1	1	39.5
2	Сумд ОНХС	2	30.0			28	580.7	103	1105	24	203.6
3	Нийт дүн	8	1418.1	0	0	30	629.2	106	1355.1	25	243.1

Сумын Засаг даргын захирамжаар томилогдсон үнэлгээний хороо, ажлын хэсгүүд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлийн

7.1²⁵, 7.2²⁶, 8.5²⁷, 7.2²⁸ “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын” 8 дугаар зүйлийн 8.2²⁹, 8.7³⁰ дахь заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- ✓ Булган суманд өвс тэжээл нөөц бэлтгэх 23.0, сумын төвөөс малтай айл өрхийг гаргаж байгаатай холбогдуулан дэд бүтцийн асуудлыг шийдэх 12.4 сая төгрөгийн өртөгтэй ажлыг тус тус шууд гэрээ байгуулсан,
- ✓ Баян-Агт суманд Баянхайрхан багийг тохижуулах 3.0, Баянзүрх багийн тэжээлийн агуулах 6.0 сая төгрөгийн олон нийтийн оролцоотой худалдан авах ажиллагааны журмаар тендер зарласан гэх боловч холбогдох нотлох баримтгүй,
- ✓ Сэлэнгэ сум нь ИТХ-аар зам засвар 24.5, сумын төвийн тохижилт 30.4 сая төгрөгийн ажлын нийт төсөв өртгийг хувааж хэд хэдэн жижиг ажил болгож шууд гэрээ байгуулсан,
- ✓ Тэшиг суманд Хогийн цэгийг тохижуулах 15.0 сая төгрөгийн өртөгтэй ажлыг шууд гэрээ байгуулсан,
- ✓ Хутаг-Өндөр сумын Уньт багийн дунд сургуулийн хоолны газрын өргөтгөл 10.0, цэцэрлэгийн засвар 6.0 сая төгрөгийн ажлыг олон нийтийн оролцоотой тендер шалгаруулалтын журмаар сонгон гүйцэтгэсэн боловч байгууллагад санхүүжилтийг олгож тухайн байгууллагын ажилчид ажлыг гүйцэтгэжээ.

Иймд алдаа зөрчлийг арилгаж, сангийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулж, худалдан авах ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг бүрэн хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авах холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцон ажиллаж үр дүнг нийтэд мэдээлэх шаардлагатай байна.

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн холбогдох заалтыг зөрчсөн 130.3 сая төгрөгийн зөрчил илэрснийг сумын Засаг дарга, холбогдох албан тушаалтанд зөрчлийг дахин давтан гаргахгүй байх, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох зөвлөмж хүргүүлж ажиллаа.

²⁵ Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна:

²⁶ Хуульд энэ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө.

²⁷ Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно.

²⁸ Сум, дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах хорин сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж болно.

²⁹ ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэрээр бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль” болон түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалыг дагаж мөрдөнө.

³⁰ ОНХС-гийн хөрөнгөөр, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй бол Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т заасны дагуу төсвөөс санхүүжилт олгохгүй

2.2.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргээс бусад төсөл, арга хэмжээнд сангийн хөрөнгийг зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.11, Сангийн сайдын 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн 288 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын дөрөвт ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх чиг үүргийг тодорхойлсон байна.

Зарим сумдын Засаг дарга нь Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ, ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх боломжтой чиг үүргүүдийг ялгахгүйгээр тус сангаас санхүүжүүлж, сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй зөрчил давтагдсаар байна.

ОНХС-гийн хөрөнгийг чиг үүргээс бусад төсөл, арга хэмжээнд зарцуулсан зөрчлийн нийт дүн

/Сая.төг/

№	Сумдын нэрс	“Дэд хөтөлбөр”		Сангийн чиг үүрэгт хамаарахгүй төсөл арга, хэмжээ		Нийт зөрчлийн дүн	
		Төсөл арга хэмжээ		Тоо хэмжээ	Төсөвт өртөг	Тоо хэмжээ	Төсөвт өртөг
1	Баяннуур сум	1	1	1	15.7	2	16.7
2	Булган сум	1	1.8			1	1.8
3	Бүрэгхангай сум	2	3.1	1	3.1	3	6.2
4	Гурванбулаг сум	1	1.0			1	1.0
5	Дашинчилэн сум	1	1.4	1	5.1	2	6.5
6	Орхон сум			1	10	1	10
7	Рашаант сум	1	2.8			1	2.8
8	Сайхан сум			3	12.3	3	12.3
9	Тэшиг сум	1	2.5			1	2.5
10	Хангал сум	2	1.8			2	1.8
11	Хишиг-Өндөр сум	1	1.0			1	1.0
12	Хутаг-Өндөр сум	2	5.8			2	5.8
13	Хялганат сум	2	2.3			2	2.3
	Нийт дүн	15	24.6	7	46.2	22	70.8

Дээрх хүснэгтээс дүгнэхэд илэрсэн зөрчлийн 68.1 хувь нь “Дэд хөтөлбөр” гэсэн төсөл хөтөлбөрийг урьдчилсан тооцоололгүйгээр төсөвт өртгийг багц дүнгээр, үлдэх

31.9 хувь Засаг даргын зөвлөлийн санал болгож эрэмбэлсэн ажил дээр ИТХ хяналт тавихгүй баталсан нь ОНХС-гийн чиг үүрэгт хамаарахгүй бусад байгууллагын урсгал зардал, ойрын хэрэгцээ шаардлагыг хангах зардалд зарцуулж байгаа нь зориулалт бус зарцуулах үндэслэл болж байна. Тухайлбал: Орхон сум ЗДТГ-ын автомашины дутуу санхүүжилт 10.0, Сайхан сум цагдаагийн газрын автомашины засварын зардал 3.6, Дашинчилэн сум сумын архивын тавиур 5.1, Баяннуур сум ЗДТГ үйлчилгээний автомашин 15.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан, бусад сумд “Дэд хөтөлбөр” төсөл хөтөлбөрийн төсөвт өртгөөс 1.0-5.8 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь дээр дурдсан журмын 4.2.3³¹, 4.2.4³², 4.2.5³³ дахь заалтуудтай нийцээгүй байна./хавсралт-1/

Аудитаар ОНХС-гийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан нийт 70.8 сая төгрөгийн зөрчилд холбогдох байгууллага, албан тушаалтанд 1.5 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 69.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг тус тус хүргүүлж ажиллалаа.

2.2.3. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 3 төсөл арга хэмжээний 86398.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчит бүртгээгүй байна.

Аймаг, сумдын ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн 85 төсөл арга хэмжээний 986563.6 мянган төгрөгийн хөрөнгийг орон нутгийн өмчит бүртгэхээс бүртгэл тайланд 82 төсөл арга хэмжээний 900155.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг бүртгэж, Бугат сум 1 төсөл арга хэмжээний 61398.6, Тэшиг сум 1 төсөл арга хэмжээний 15000.0, Хутаг-Өндөр сум 1 төсөл арга хэмжээний 10000.0 мянган төгрөгийн хөрөнгийг тус тус орон нутгийн өмчит бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4³⁴, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2³⁵ дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна. Дээрх зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ.

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн төлөвлөлт, хэрэгжилтийг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан үү?

Бүлэг III

ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд холбогдох хяналт шалгалтыг хийжээ.

³¹ Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.11-д зааснаас бусад төрлийн үйлчилгээний зардал

³² Аливаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал

³³ Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас бусад улсын төсвийн байгууллагын хөрөнгийн зардал

³⁴ Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ...

³⁵ Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна.

3.1.1. ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөтөлбөр, төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад аймгийн ИТХ, санхүүгийн хяналт дотоод аудит хяналт, шалгалтыг хийж, сумын ИТХ зөвхөн ОНХС-гийн гүйцэтгэлд хяналт тавьсан байна.

Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “ОНХС-гийн үйл ажиллагааны журам”-ын 9.4-д “ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэл болон энэ журмын хэрэгжилтэд ...аймаг, ... сумын ИТХ-ын дэргэдэх хороо ...Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, ...нийцүүлэн гаргасан хууль тогтоомжид заасан чиг үүргийн дагуу хяналт тавина.” гэж заажээ.

Аудитаар ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлд дээрх журамд заасан хяналт тавих эрх бүхий байгууллагуудын хяналт шалгалтын ажлын удирдамж, тайланг үзэхэд:

- Аймгийн ИТХ-ын эдийн засгийн хөгжил, төсөв санхүүгийн хороо, Санхүүгийн Хяналт аудитын албатай хамтарсан хяналт шалгалтыг 2020 онд Могод, Хутаг-Өндөр, Орхон, Тэшиг, Бугат сумдын 2018, 2019 оны ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад, 2019 онд Хялганат тосгон, Хангал, Сайхан, Баян-Агт, Рашаант, Бүрэгхангай сумдын 2017, 2018 оны ОНХС-гийн зарцуулалтад тус тус хяналт тавьж ажилласан байна.
- Сумдын ИТХ-аас батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу 2019 оны ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажилласан боловч зөвхөн сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлд тус тус хяналт шалгалтыг хийж, сангийн төлөвлөлт, тайлагналт, бүртгэлд тавих хяналтыг хийгээгүй байгаа нь Сангийн сайдын 2018 оны “ОНХС-гийн үйл ажиллагааны журам”-ын 9.4 заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Иймд сумдын ИТХ ОНХС-гийн сангийн хөрөнгийн төлөвлөлтийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөж байгаа эсэхэд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

3.1.2. Аймаг, сумын захиргааны байгууллагууд ОНХС-гийн хэрэгжилт, үр дүнд хяналт, шинжилгээ үнэлгээг холбогдох журмын дагуу хийж гүйцэтгээгүй байна.

Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “ОНХС-гийн үйл ажиллагааны журам”-ын 9.5-д ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны “Журам шинэчлэн батлах тухай” 89 дүгээр тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн захиргааны байгууллагууд хийнэ” гэж заажээ.

Аудитаар дээрх журмыг аймаг, сумдын захиргааны байгууллага хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд зөвлөмж хүргүүлж ажиллалаа.

3.2.1. Холбогдох мэргэжилтнүүд ОНХС-гийн төсвийн гүйцэтгэлийн тайлан, хэрэгжилтийн тайланг дээд шатны байгууллагад хүргүүлсэн боловч журамд заасан хугацааг баримтлаагүй байна.

Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар баталсан “ОНХС-гийн үйл ажиллагааны журам”-ын 9.2-д “Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж дараа оны 2 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө, оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлэх...” гэж заажээ.

Сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нь ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө, оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн боловч журамд заагдсан хугацааг баримтлаагүй 2 дугаар сарын 14-нөөс 3 дугаар сарын 13-ны хооронд хугацаа хоцроон хүргүүлсэн, тухайн тайланд журамд заагдсан мэдээллийг бүрэн багтаагаагүй нь ОНХС-гийн үйл ажиллагааны журмын 9.2 дахь заалттай бүрэн нийцэхгүй байна.

Иймд аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь сумдын Засаг дарга нарт ирүүлж байгаа ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг холбогдох журамд заасан мэдээллийг бүрэн багтаасан тайланг ирүүлэх зөвлөмж зааврыг хүргүүлэх шаардлагатай байна.

Аймаг, нийслэлийн ХОХБТХ нь ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг гарган, дүгнэлт өгч, санал боловсруулан тухайн шатны Засаг даргад танилцуулан сумдад холбогдох зөвлөмжийг хүргүүлсэн, мөн ОНХС-гийн хэрэгжилтийн тайлан, гаргасан шийдвэрийг тухайн шатны ИТХ-аар хэлэлцүүлэн дээрх журмын 9.3³⁶, 9.7³⁷-д заасан заалтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн ХОХБТХ нь ОНХС-гийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж, жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус журмын 9.9-д заасныг мөн хэрэгжүүлэн ажилласан байна.

³⁶ Аймаг, нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-гийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.

³⁷ Энэ журмын 9.3-т заасан дүгнэлт, Засаг даргын шийдвэрийг тухайн шатны ИТХ-аар жил бүр, төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн талаарх Засаг даргын мэдээллийн хамт хэлэлцүүлнэ.

3.2.2. Өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлагыг 100 хувь, зөвлөмжийг 75 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

ОНХС-гийн 2018 оны хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн нийцлийн аудитаар төлбөрийн акт 1, албан шаардлага 4, аймгийн Засаг даргад 4 зөвлөмж хүргүүлснээс төлбөрийн актын биелэлт 100 хувь, албан шаардлагын биелэлт 100 хувь, зөвлөмжийг биелэлт 75 хувь тус тус хэрэгжүүлсэн байна.

ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал аваагүй, ТЭЗҮ хийгдээгүй төсөл арга хэмжээг төлөвлөж ИТХ-аар батлуулсан сумын Засаг дарга нарт энэ зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж хүргүүлнэ гэсэн 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.

3.2.3. Сангийн үйл ажиллагаа нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгодоо хүрч байгааг сүүлийн жилүүдэд ОНХС-гийн эх үүсвэр жил ирэх тусам буурч байгаатай холбогдуулан ОНХС-гийн хөрөнгийг богино хугацааны хэрэгцээ шаардлага хангах зардалд зарцуулж байна.

Орон нутгийн хөгжлийн сангаар хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээг хэрэгжүүлж эхэлснээс хойш олон нийт, багийн иргэдээс санал авах ажил жигдэрсэн, сумдад бүлгийн зохион байгуулалтаар ажлын байр бий болсон, олон нийт ч үүнд ач холбогдол өгдөг болсон, зарим газар цахимаар санал авч байгаа, сум, орон нутаг, байгууллага, олон нийтийн эзэмшлийн газрын тохижилт, засвар үйлчилгээ, тухайн жилд болон цаашид ач холбогдолтой арга хэмжээнд хөрөнгө зарцуулж үр дүн гарсан сайн талууд олон байна.

Тухайлбал 2013-2019 онд Булган, Сэлэнгэ, Могод, Сайхан, Орхон, Баян-Агт Хангал, Тэшиг, Бугат, Бүрэгхангай сум, Хялганат тосгонд суманд хатуу хучилттай зам, төмөр бетонон гүүр тавьсан, сумыг иж бүрэн камержуулсан, Соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн байгуулсан, ахмадын сувилал, сургуулийн дотуур байр, спорт заалны барилга барьсан, өргөтгөл, засвар хийсэн, төв суурин газрын гэрэлтүүлэг, цэвэр, бохир усны шугамын өргөтгөлүүд, аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийг шаардлагатай багаж, тоног төхөөрөмжөөр хангасан зэрэг 24 томоохон ажил хийгдсэн нь орон нутгийн иргэдийн ая тухтай амьдрах орчин, нөхцөлийг сайжруулахад бодитой үр өгөөжөө өгч байна.

Жил бүр хийсэн аудитаар

- Иргэдээс санал аваагүй төсөл, арга хэмжээг аймгийн ИТХ-аас баталсан “Дэд хөтөлбөр” нэрийн доор сумын ИТХ дур мэдэн нэмж баталдаг,
- Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хүлээж авахдаа сум, орон нутгийн иргэд, олон нийтийн оролцоог хангадаггүй,
- Техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв батлагдаагүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлдэг, зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгэх гэхээр бараг төсөвт өртгөөсөө өндөр үнэтэй байдаг тохиолдол ч гарсан,

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглосон зардал, төсөл арга хэмжээнд санхүүжилт олгодог,
- Орон нутагт хэрэгжүүлсэн гэрэлтүүлэг, нийтийн өмчид хамаарах хөшөө, дурсгал, зам талбайн арчлалт, хамгаалалтын зардлыг цаашид хэрхэн шийдвэрлэхэд хүндрэлтэй,
- Аймгийн хэмжээнд 2-3 жил дараалан иргэдийн санал аваагүй сумдын цагдаагийн хэсгүүдэд суудлын автомашин, торгуулийн машин, драйвер худалдан авч өгсөн, олон нийтийн цагдааг цалинжуулсан нь орон нутгийн хөгжилд нэмэр болохуйц үр дүн гараагүй зэрэг зөрчил гарсаар байгаад дүгнэлт хийж зөрчлийг дахин давтахгүй байхад хууль, журамд шинэчлэл хийх шаардлагатай байна.

ОНХС-гийн зорилгыг “Орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэд тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ” хэмээн тодорхойлсон ч ОНХС-гийн хөрөнгийн эх үүсвэр эил бүр буурч байгаатай холбогдон орон нутгийн хөгжил эдийн засгийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтад бус, богино хугацааны хэрэгцээ, шаардлага хангах хөрөнгө оруулалт, урсгал зардалд зарцуулж байна.

Тухайлбал: Олон нийтийн цагдаа, морин хуурын багшийн цалин, урамшуулал, дэд хөтөлбөрүүдийн хүрээнд хийгддэг уралдаан тэмцээний шагнал, шатахуун, сурталчилгааны материалын зардал, орон нутагт хэрэгжүүлсэн гэрэлтүүлэг, нийтийн өмчид хамаарах хөшөө, дурсгал, зам талбайн арчлалтын зардал зэрэгт зарцуулж байна.

Мөн Төсвийн тухай хуулийн 60.3.3-д заасан заалтыг үндэслэн сумууд үндэсний их баяр наадмын зардлыг 3.0-46.0 сая төгрөгийн хооронд харилцан адилгүйгээр ИТХ-аар батлуулж зарцуулж байна.

Цаашид аймаг, сумын орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлттэйгөө уялдуулан томоохон, хөрөнгө оруулалтын шинж чанартай ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх нь зүйтэй байна.

Аудитаар ОНХС-гийн хөрөнгөөр илэрсэн нийт 818.6 сая төгрөгийн зөрчилд холбогдох байгууллага, албан тушаалтанд 1.5 сая төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоож, 92.8 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 724.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх, зөрчил гаргасан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох, үр дүнг мэдээлэх зөвлөмжийг хүргүүллээ.

Иргэдээс авсан санал асуулгын нэгтгэл:

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа орон нутагт хэрхэн хэрэгждэг, иргэдэд сурталчилдаг эсэх, иргэдэд хүртээмжтэй, үр дүнтэй хэрэгждэг эсэхийг тодорхойлсон санал асуулгад 16 сум 1 тосгоны 519 иргэн судалгаанд хамрагдсан. /Дэлгэрэнгүйг судалгааны нэгтгэлээс үзэх/

Та орон нутгийн хөгжлийн сангийн талаарх холбогдох хууль тогтоомж, журам зааврыг судалж үзсэн үү? гэсэн асуултад 47.6 хувь нь тийм, 52.4 хувь нь үгүй гэж хариулсан нь иргэдийн орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын мэдлэг хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Судалгаанд хамрагдсан 519 иргэдээс ач холбогдол бүхий дараах саналуудыг өгчээ. Үүнд:

- ОНХС-гийн хөрөнгөөр томоохон худалдааны төв, барилга байгууламж барих,
- ОНХС-г цаашид хэрэгжүүлэх хэрэгтэй,
- ОНХС хариуцсан ажилтан хөдөө багуудаар явж, иргэдэд сургалт сурталчилгаа хийдэг байх,
- ОНХС-гийн санхүүжилт хугацаандаа хийгддэг байхад анхаарах,
- ОНХС-гийн хөрөнгө оруулалтын хувьд урьдчилсан тооцоо судалгааг сайжруулах талаар сургалт зөвлөгөө өгдөг байх,
- ОНХС-гийн хөрөнгийг нэмэгдүүлэх гэсэн саналыг эрэмбэлж тусгалаа.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын үр дүнд үндэслэж дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль болон ОНХС-ийн үйл ажиллагааны журамд заасны дагуу аймаг, сумд ОНХС-ийн хөрөнгийн эх үүсвэрийг эх үүсвэр тус бүрээр төлөвлөж, бүрдүүлэх нөхцөл боломж байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийг төлөвлөж батлахдаа иргэдээс санал аваагүй, зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй сангийн зорилгод нийцээгүй төсөл, хөтөлбөрийг ИТХ баталдаг зөрчил давтагдсаар байна.
- Аудитаар ТБОНӨХБАҮХАТ хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 8.5, “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын” 8 дугаар зүйлийн 8.2, 8.7 дахь заалтыг тус тус зөрчин 130.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл арга хэмжээг гүйцэтгэсэн байна.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг зарцуулахыг хориглосон зардал, төсөл арга хэмжээнд санхүүжилт олгосон зэргээс орон нутгийн хөгжлийн сангийн зардлын гүйцэтгэлд тавих хяналт сул байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчит бүртгэх ажил сайжирч байгаа ч 3 сум нийт 86398.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалтыг бүртгэл тайланд тусгаагүй байна.
- ОНХС-ийн хэрэгжилт, үр дүнд хяналт, шинжилгээ үнэлгээг холбогдох журмын дагуу хийж гүйцэтгээгүй байна.
- ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжил, эдийн засгийн ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтад бус, богино хугацааны хэрэгцээ шаардлага хангах зардалд төлөвлөн зарцуулж байна.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна.

Булган аймгийн Засаг дарга Б.Ариун-Эрдэнэ танаа:

1. ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал аваагүй, ТЭЗҮ хийгдээгүй, урьдчилсан тооцоолол, зураг, төсөвгүй сангийн зорилгод нийцээгүй төсөл арга хэмжээг ИТХ-аар батлуулахгүй, аймгийн ХОХБТХ-т ирүүлэх ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайлангийн мэдээллийг бүрэн багтаасан тайланг ирүүлэх, холбогдох хууль, журмыг бүрэн хэрэгжүүлэн ажиллах талаар сумын Засаг дарга нарт чиглэл өгөх,
2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явцад хяналт, шинжилгээ үнэлгээг ОНХС-ийн үйл ажиллагааны журмын 9.5-д заасан захиргааны байгууллагаар хийлгэх.
3. Хууль журамд заасан шаардлага хангагдаагүй төсөл, арга хэмжээг баталсан, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй, үйл ажиллагаанд бүхэлд нь хяналт тавих үүргээ хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил гаргасан албан тушаалтнуудад хариуцлага тооцож, зөрчил давтан гаргахгүй байх талаар тодорхой арга хэмжээ авч, үр дүнг мэдээлэх.

Мэдэгдэл:

Нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилган, өгсөн зөвлөмжийн хэрэгжилт гарсан үр дүнгийн талаар 2020 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр хариу ирүүлэх.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Г.НАМЧИНСҮРЭН

АУДИТОР

З.ГАНБААТАР

